
LOCTITE

**1001, Trout Brook Crossing,
Hill, CT 06067-3910
Telephone: (860) 571-5100
FAX: (860) 571-5465
FAX: 01707 358900**

Production Description Sheet
**NordBak® Ultra High Temperature Rocky
Wearing Compound**
Maintenance, Repaire & Operations,
May 2005

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЙЛБАР

LOCTITE® 7229 Nordbak® Ultra High Temperature Wearing Compound нь -29°C -ээс 288°C температурт ажилладаг бөгөөд хуурай материалын урсгалд хүчтэй зүлгэгддэг тоног төхөөрөмжийг сэлбэн засах, хамгаалах, шинэчлэх зорилгоор ашиглагддаг бүтээгдэхүүн юм. Ultra High Temperature Wearing Compound нь өндөр температурт ажилладаг, уламжлалт аргаар засварлах боломжгүй тоног төхөөрөмжийг хамгаална. Эдгээрийг шүүлтүүр (scrubbers), циклон (cyclones), тоос хураагуур (dust collectors) болон сэнсний үүр (fan housings) зэрэг тоног төхөөрөмжийг элэгдлээс хамгаалах зорилгоор ашиглана. Энэ бүтээгдэхүүний бүрэлдэхүүнд хоёр төрлийн епоксид орох ба хатсаныхаа дараа өндөр температурт тэсвэртэй сайн ажиллана.

Ашигтай тал:

- Хатахаараа цахиур шиг хатуу болох ба хүчтэй зүлгэдэг хуурай материалын урсгалд тэсвэртэй
- Тоног төхөөрөмжийн элэгдсэн хэсгийг хурдан сэргээж ашиглалтын хугацааг уртасгана.
- Хүчтэй зүлгэдэг хуурай материалын урсгалд тэсвэртэй учир тоног төхөөрөмжийг элэгдлийг багасгаж сэлбэг материалын зардлыг багасгана.
- Агшдаггүй, доош гоождоггүй (Non sag) учир босоо, барзгар, болон доош харсан гадаргууд ашиглахад тохиромжтой

НИЙТЛЭГ ХЭРЭГЛЭЭ

- Циклон (cyclones) болон тээрэм
- Мүхрүй тахир хэсэг (elbows)
- сэнсний далбаа болон сэнсний үүр (fan blades and housings)
- шүүлтүүр (scrubbers),
- Гаргах хоолой (exhausters)
- Юүлэх, хуваарилах цорго (hoppers)

ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Гадаргууг цэвэрлэж бэлдэх:

Энэ бүтээгдэхүүнүүд нягт сайн цэвэрлэж бэлтгэсэн гадаргууд удаан тогтоно. Бүтээгдэхүүнд тавих шаардлага нь уг бүтээгдэхүүний ажиллах нөхцөл, ашиглах ба үйлчилгээ хийх хугацаа болон үндсэн бодисын найрлагаас шалтгаалан өөр өөр байж болно.

-
1. Бүх төрлийн босоо болон доош харсан гадаргууд Ultra High Temperature Wearing Compound ашиглахдаа эхлээд тэр гадаргуу дээрээ метал торон суурь (tack welding expanded metal mesh) бэхлэх ёстой.
 2. Элэгдэж муудсан гадаргууг зүлгэж сайтар зүлгэж цэвэрлэ. Боллоцотой бол бүх гадаргууд Near White Metal (SSPC-SP10/NACE No. 2) стандартаар элсэн цэвэрлэгээ хийх хэрэгтэй. Урьдчилсан бэлтгэл бага шаардах гадаргууд гар багажаар зүлгэж болно.
 3. Уг гадаргууг уусгагч бодисоор цэвэрлэх тохиолдолд мөр үлдээдэггүй уусгагч бодис ашиглах хэрэгтэй.

Холих

1. Энэ бүтээгдэхүүнийг холихдоо резин ба хатаагчаа эзлэхүүн юмуу жингээр нь 2.5:1 харьцаагаар аваад хуурай, цэвэр гадаргуутай холих савандаа хийгээд нэгэн жигд өнгөтэй болтол хутга. (Хэрэв резин болон хатаагчийн температур 15°C -ээс доош хэмтэй байвал зөвхөн резинээ 32°C орчим (38°C -ээс хэтрүүлэхгүй) бүлээсгэнэ.

Хэрэглэх арга

1. Урьдчилан цэвэрлэж бэлдсэн гадаргуу дээр бодисуудаа бүрэн сайн хольж хэрэглэнэ.
 2. Холимогийн эхний үеийг маш нимгэн зөвхөн “норгох төдий” тавих ба түрхэцийн үе дотор агаарын бөмбөлөг үүсэж болохгүй
 3. Дараа нь холимогоо зохих зузаанд нь хүртэл нэмж (0.64см -ээс багагүй) түрх
 4. Агаарын хэм 25°C байхад ажлаа 30 минутад дуусгах боловч ажил гүйцэтгэх ба бэхжих бэхжих хугацаа орчны температур болон гадаргуугийн массаас хамаарна. Температур өндөр байх, гадаргуугийн масс их байх тусам бэхжих хугацаа хурдан болно.
 5. Хатаж гүйцсэний дараа 148°C хэмд 2 цаг хатаана.
- **Санамж!** Хатаж бэхижсэн бодистой хэсгийн ойролцоо гагнуур хийх, хийн гагнуураар таслах ажил хийх бол зөвшөөрөгдсөн, соролт бүхий, шүүлтүүртэй респиратор зүүх ёстой. Хаалттай орчинд хатаж бэхижсэн бодистой хэсэгт халаах, гагнуур хийх, хийн гагнуураар таслах ажил хийх бол зөвшөөрөгдсөн, соролт бүхий, хувийн амьсгалын аппарат өмсөж ашиглах хэрэгтэй.
 - Хатаж бэхижсэн бодистой хэсэгт машинаар зүлгэх, таслах ажил хийх тохиолдолд тоос болон манангаас хамгаалах зориулалттай респиратор зүүх ёстой. Хатаж бэхижсэн бодистой хэсгийн ойролцоо **ил гал гаргахыг хориглоно**. Холбогдох бусад санамжуудыг Аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудаснаас үз.

ЕПОКСИДТЭЙ АЖИЛЛАХ ТЕХНИКИЙН ЗӨВЛӨМЖ

Ажлын цаг ба бэхжилт нь орчны температур ба жин хэмжээ (масс)-нээс хамаарна:

- Температур өндөр байх тусам хурдан бэхжинэ
- Материалын жин хэмжээ (масс) их байх тусам хурдан бэхжинэ

Нам температурт эпоксидын бэхжилтийг түргэтгэхийн тулд:

- Эпоксидоо тасалгааны температурт хадгал.
- Засварлах гадаргуугаа урьдчилан бүлээсгэх хэрэгтэй.

Өндөр температурт эпоксидын бэхжилтийг сааруулахын тулд:

- Эпоксидоо хурдан хатаахгүйн тулд бага багаар холь.
- Бүрэлдэхүүн хэсгүүдээ (Резин/хатаагч) хөргөх.

БЭХЭЖЭЭГҮЙ МАТЕРИАЛЫН НИЙТЛЭГ ШИНЖ ЧАНАР

Холимог

Нийтлэг хэмжээ

Харагдах байдал

Өтгөн саарал зуурмаг

Холих харьцаа - Mix Ratio (R:H) Эзлэхүүнээр

2.5:1

Холих харьцаа - Weight жингээр

2.85:1

Бүрхэх орц - Coverage

0.8 м² талбайг 6 мм зузаантай бүрэхэд
25lb kit.

БЭХЖИХ НИЙТЛЭГ ТӨЛӨВ

(Өөрөөр заагаагүй бол 25 °C хэмд)

Бэхжих шинж чанар

Нийтлэг хэмжээ

Ажил гүйцэтгэх хугацаа мин: -Working Time, minutes

30

Хатах хугацаа-

Хатаж бэхжиснээс хойших хугацааг
Хэрэглэх заавраас үз

БЭХЭЖСЭН МАТЕРИАЛЫН НИЙТЛЭГ ШИНЖ ЧАНАР

(Өөрөөр заагаагүй бол 25 °C хэмд)

Физик шинж чанар

Нийтлэг хэмжээ

Хатуулаг - Hardness ASTM D-2240, Shore D

90

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэ бүтээгдэхүүнийг дан хүчилтөрөгч/хүчилтөрөгч ихтэй системд хэрэглэхэд зохимжгүй бөгөөд хлортой юмуу хүчтэй исэлдүүлэгч материалуудыг хааж тусгаарлах зорилгоор ашиглаж болохгүй. Эдгээр бүтээгдэхүүнийг ашиглахдаа баримтлах мэдээллийг Аюулгүй ажиллагааны дагалдах хуудаснаас үзнэ үү.

Захиалах мэдээлэл

Хэсгийн дугаар	Контейнерийн хэмжээ
96392	25 lb. kit

Хадгалалт

Эдгээр бүтээгдэхүүнийг хуурай сэрүүн газар битүүмжилсэн контайнерт 2°C – ээс 8°C хэмд хадгалах хэрэгтэй. Бүтээгдэхүүний хадгалалтын горимын мэдээллийг контайнер дээрх шошгонд үзүүлсэн байж болно.

Хадгалалтын тохиромжтой нөхцөл нь дээрх хязгаарын доод хэсэгт заасан хэм болно. Контайнерээс гаргаж авсан бүтээгдэхүүн ашиглалтын явцад бохирдож болно. Иймээс нэгэнт гаргаж авсан бүтээгдэхүүнийг эргүүлж контайнерт нь хийж болохгүй. Бохирдсон болон хадгалалтын журамд зааснаас өөр орчинд хадгалсан бүтээгдэхүүний талаар Хенкел корпораци хариуцлага хүлээхгүй. Хэрэв нэмэгдэл мэдээлэл шаардлагатай бол ойр орших Техникийн үйлчилгээний төв юмуу Хэрэглэгчид үйлчлэх төлөөлөгчийн газарт хандах хэрэгтэй.

Өгөгдлийн хязгаар

Энд дурьдсан мэдээллийн хэмжээ хязгаарыг нийтлэг дундажаар нь авсан байж болно. Эдгээр мэдээллүүд бүтээгдэхүүний туршилтын үр дүнд үндэслэгддэг ба үе үе шалгалтанд ордог болно.

Мэдэгдэл

Уг бүтээгдэхүүнийг ашиглахад зориулсан энэхүү мэдээлэл найдвартай мэдээлэл болно. Манай бүтээгдэхүүнийг бидний хяналтгүй нөхцөлд ашиглан хүрсэн үр дүнд компани хариуцлага хүлээхгүй. Манай бүтээгдэхүүн танай хэрэгцээнд тохирох эсэхийг өөрсдөө урьдчилсан туршилтаар тогтоох хэрэгтэй. Уг бүтээгдэхүүнийг ашиглахдаа ажиллагсдынхаа аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах нь хэрэглэгчдийн хариуцах зүйл байх ёстой. **Loctite Corporation энд дурьдсан болон мөрдөгдөж байгаа (үүний дотор манай бүтээгдэхүүнийг арилжаж, хэрэглэх, тухайн зорилгод нийцсэн эсэхтэй холбоотой) баталгаанууддыг хариуцахгүй болно. Түүнээс гадна санамсаргүй тохиолдлоор үүссэн ямар нэг эвдрэл гэмтэл, хохирол үүний дотор алдсан ашигийг хариуцахгүй болно.** Энд дурьдсан төрөл бүрийн процесс, тэр процессын бүрэлдэхүүн хэсгүүдэд тус компанийн болон бусдын эзэмшдэг патент, лицензийн эрх давамгайлахгүй гэж ойлгож болохгүй. Тиймээс хэрэглэгч бүр тэдгээр процессыг давтах талаар өргөдөл гаргахаасаа өмнө тэдгээр эзэмшигчдийн мэдээллийн санг шалгаж мөрдөж байхыг зөвлөж байна. Зарим бүтээгдэхүүн АНУ болон гадаад орны нэг буюу хэд хэдэн патентаар хамгаалагдсан эсвэл патентын өргөдөлтэй байж болно.